Сант сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/32 дугаар захирамжийн хавсралт

САНТ СУМАНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Эзэмшүүл-эх газрын хэмжээ /га/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/	Дэнчин-гийн хэмжээ /мян.төг/
1	5-р баг Өвсний фондны зүүн талд	ХАА-н үйлдвэрлэл цогцолбор	0.2	960.000	96.000

-o0o-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/33 Майхан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийг Ивээх Сан “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол олгох төсөл” зорилтот 5 аймгийн сургуулиудын дунд зарлагдсан “Сурууульд суурилсан энтерпрайз” төслийн тогтвортой байдлыг хангаж Энтрепренершипийн боловсрол, үйл ажиллагаар орон нутагтаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж дээрх зарлагдсан төслийн сонгон шалгаруулалтанд төслийг бичиж илгээх, төслийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Ганчимэг (ЕБС-ийн захирал)
Нарийн бичгийн дарга: И.Алтанцэцэг (Ахлах ангийн сургалтын менежер)
Гишүүд: Г.Дулмаа (Бага ангийн сургалтын менежер)
Д.Мядаг (Биологийн багш)
Д.Шинэтуяа (МХБУЗ багш)
Д.Лувсанбалдан (НТБАЗ)
Л.Пүрэвдулам (Нягтлан бодогч)

2. Энтрепренершип боловсрол олгох төслийн үйл ажиллагаа , Сургуульд суурилсан Энтерпрайз төслийг амжилттай хэрэгжүүлэх тогтвортой байдлыг хангах цаг тухай бүрд үйл ажиллагаag тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

10600000

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/34 Майхан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.5, 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний спортын 7 дугаар их наадамд оролцох баг, тамирчдыг бэлтгэх, оролцоог хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: О.Ганпүрэв(Засаг даргын орлогч)
Гишүүд: Б.Батбаяр (Шагайн зөвлөлийн тэргүүн) (Зөвшилцсөнөөр)
Байгууллагын дарга, эрхлэгч нар
Багийн Засаг дарга нар
Д.Ганхуяг (Биеийн тамирын багш)
Д.Гантулга (Биеийн тамирын багш)

2. Үндэсний спортын 7 дугаар их наадамд оролцох баг, тамирчдыг бэлтгэж, тамирчдын мэдүүлгийг хугацаанд нь аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газарт албан бичгээр хүргүүлж, анхан шатны тэмцээнд өндөр зохион байгуулалттай оролцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (О.Ганпүрэв)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

10600000C

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/35 Сант сум

Дотоод хяналт шалгалтын нэгж
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2, 1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын дотоод хяналт шалгалтын нэгжийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Бат-Эрдэнэ (Засаг даргын тамгын газрын дарга)
Нарийн бичгийн дарга: М.Отгонбат (Санхүү албаны дарга)
Гишүүд: Б.Батбаяр (Хурлын нарийн бичгийн дарга) (Зөвшилцсөнөөр)
Г.Буянтогтох (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)
Т.Цэндмаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

2.Дотоод хяналт шалгалтын журам боловсруулан батлуулж, байгууллагуудын санхүү болон үйл ажиллагаа, дотоод бичиг баримтанд хяналт шалгалт хийн, заавар зөвлөмж өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан тайлан мэдээг хугацаанд хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Бат-Эрдэнэ), Нарийн бичгийн дарга (М.Отгонбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

1С6000008

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/36 Сант сум

Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн
удирдах бүрэлдэхүүн шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар баталсан "Мэргэжлийн ангийн дүрэм"-ийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт, бүтэц зохион байгуулалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүтцийн дагуу ажилтан, албан хаагчдыг томилж, үүргээр хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан (О.Ганпүрэв)-д даалгасугай.

3.Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн дарга (Г.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн шинэчлэн томилох тухай" А/25 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

106000007
D:My.Doc.Zahiramj.zasag darga

Сант сумын Засаг даргын 2022 оны...03...
дугаар сарын ...22...ны өдрийн...А/36...дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТТАЙ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН

Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн дарга: Г.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Мэргэжлийн ангийн орлогч бөгөөд сургалт, суралчилгаа хариуцсан ажилтан: О.Ганпүрэв (Засаг даргын орлогч)

Холбоо мэдээлэл хариуцсан ажилтан: Ц.Чанцалдулам (Холбооны эрхлэгч)

Аюулгүй байдал хариуцсан ажилтан: Х.Гантуяа (Мал эмнэлгийн улсын байцаагч)

Хангалт хариуцсан ажилтан: М.Отгонбат (Санхүү албаны дарга)

-o0o-

Сант сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22 ны өдрийн A/36 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

САНТ СУМЫН ОНЦГОЙ КОМИСС, ГАМШГААС ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИ БҮРЭЛДЭХҮҮНИЙ УТАСНЫ ЖАГСААЛТ

№	Овог, нэр	Эрхэлж буй ажил	Томилгоот албан тушаал	Гэрийн хаяг	Утас
Онцгой комиссын гишүүд					
1	Б.Адъяатогтох	Засаг дарга	Сумын Онцгой комиссын дарга	Төв	99902109
2	Г.Бат-Эрдэнэ	ЗДТГ-ын дарга	Мэргэжлийн ангийн дарга	8 айлын орон сууц	99329433
3	О.Ганпүрэв	Засаг даргын орлогч	Ангийн орлогч дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын байрны дарга	Залаа хороолол	99998956
4	Ц.Мөнхдэлгэр	Хэсгийн цагдаа	Гишүүн	Төвийн хороолол	80636413
5	М.Отгонбат	Санхүү албаны дарга	Хангалт хариуцсан ажилтан	Залаа хороолол	99320299
6	Б.Соёлмаа	ЭМТ-ийн эрхлэгч	Гишүүн	Залаа хороолол	89994948
7	Б.Отгонбат	Соёлын төвийн эрхлэгч	Гишүүн	Төв, 12 айлын орон сууц	88978087
8	Ч.Ганчимэг	ЕБС-ийн захирал	Гишүүн	Төв, 12 айлын орон сууц	95081991
9	Х.Мөнхцэцэг	СӨББ-ын эрхлэгч	Гишүүн	Төв, 12 айлын орон сууц	99228485
10	Г.Буянтогтох	Хууль, эрх зүйн мэргэжилтэн	Гишүүн	Залаа хороолол	99984354
11	Х.Гантуяа	МЭУБайцаагч	Аюулгүй байдал хариуцсан ажилтан	Энгэр хороолол	88326660
12	Г.Батзаяа	БОХУБайцаагч	Гишүүн	Залаа хороолол	95557796
13	Ч.Баярбат	Газрын даамал	Гишүүн	Төвийн хороолол	80195154
14	Т.Цэндмаа	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Төвийн хороолол	99575226
15	Б.Өлзийбат	Эрчим хүч	Гишүүн	Төвийн хороолол	99324612
16	Д.Батбаяр	1-р БЗДарга	Гишүүн	Энгэрийн хороолол	88600128
17	О.Алтангэрэл	2-р БЗДарга	Гишүүн	Залаа хороолол	88168832
18	С.Жаргалсайхан	3-р БЗДарга	Гишүүн	Төвийн хороолол	89405059
19	Д.Чанцал	4-р БЗДарга	Гишүүн	Энгэрийн хороолол	88047408
20	Ц.Энхболд	5-р БЗДарга	Гишүүн	Залаа хороолол	89248423
1	**Г.Бат-Эрдэнэ**	**ЗДТГ-ын дарга**	**Мэргэжлийн ангийн дарга**	**8 айлын орон сууц**	**99329433**
2	О.Ганпүрэв	Засаг даргын орлогч	Ангийн орлогч дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын байрны дарга	Энгэрийн хороолол	99998956

3	Т.Цэндмаа	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Холбоо Зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Төвийн хороолол	99575226 88921264
4	Х.Гантуяа	МЭМАБУБайцаагч	Аюулгүй байдал хариуцсан ажилтан	Төвийн хороолол	88326660 88811495
5	**Ч.Баярсайхан**	**ЗДТГ-ын мэргэжилтэн**	**Аврах бүлгийн дарга**	**Залаа хороолол**	**99213656**
6	С.Мөнхбат	Байрны жижүүр	Аврагч	Төвийн хороолол	89138066
7	Т.Ишдорж	Татварын байцаагч	-"-	Залаа хороолол	99010219
8	Б.Отгонбат	Соёлын төвийн эрхлэгч	-"-	Залаа хороолол	88978087
9	Д.Гантулга	Багш	-"-	Энгэрийн хороолол	89991869
10	Г.Батзаяа	БОХУБайцаагч	-"-	Залаа хороолол	95557796 86443386
11	П.Гомбо	Багш	-"-	Майхны ар	88818483
12	Д.Батбаатар	ЕБС нярав	-"-	Энгэрийн хороолол	95059574
13	Т.Базарсад	Нийгмийн ажилтан	-"-	Төвийн хороолол	93121616
14	Ц. Бямбасүрэн	Байрны багш	-"-	Майхны ар	88778887
15	Ц.Баяр	Жолооч	-"-	Төвийн хороолол	86999707
16	Б.Түвшинбаяр	Багш	-"-	Майхны ар	88725625
17	Б.Пүрэвсүрэн	СӨББ	-"-	Энгэр хороолол	88354445
18	Ч.Баярбат	Газрын даамал	-"-	Төвийн хороолол	80195154
19	Ц.Баянчимэг	Багш	-"-	Энгэрийн хороолол	88664595
20	Ч.Баярмандах	Соёлын төв	Хөгжмийн багш	Мал эмнэлгийн хороолол	89610629
21	Д.Жанлавцогзол	Багш	-"-	Төвийн хороолол	88821774
22	н.Далайням	Төрийн банк	-*-	Төв	88079288
23	Д.Ганхуяг	Багш	-"-	Төвийн хороолол	88966684
24	М.Мөнх-Од ӨВР 00-16	ЗДТГ-ын Жолооч	Жолооч	Залаа хороолол	86961646
25	Д.Лувсанбалдан	АБ-ын арга зүйч	-*-	Энгэрийн хороолол	80559944
26	Х.Ойдовжунай	СӨББ	-*-	Майхан	86811208
27	Б.Түвшинжаргал	Багш	-*-	Майхан	
28	**Д.Ням-Алдар**	**Эрчим хүчний эрхлэгч**	**Механикжуул сан бүлгийн дарга**	**Энгэрийн хороо**	**89358228**
29	Б.Мөнхсоёл	Соёлын төвийн бүжгийн багш	Туслах ажилтан	Энгэрийн хороолол	89610629
30	Д.Батбаатар ӨВА 01-34	ИТХ хурал	Жолооч	Төвийн хороолол	88551128
31	С.Батдорж	"Арвай илч" ХХК-ийн галч	Цахилгаанчин	Энгэрийн хороолол	89645000
32	Б.Батзаяа	ТБ	Теллер	Залаа хороолол	88332361
33	Б.Мөнхзул	ЗДТГазар	Халамжийн мэргэжилтэн	Майхны ар	88669556
34	Л.Жаргалсайхан	Онги-Ус суваг	-"-	Төвийн хороолол	89849899
35	М.Эрдэнэчулуун	Зорчигч тээвэр	Жолооч	Энгэрийн хороолол	88811799
36	Б.Өлзийбат	Монтёр	-"-	Энгэрийн хороолол	99324612

37	**Т.Санлигмаа**	**ЭМТ**	**Эмнэлгийн бүлгийн дарга**	**Майхан хороолол**	**88863133**
38	Г.Мягмарсүрэн	ЭМТ	Багийн эмч	Залаа хороолол	96112204
39	Л.Ичинхорлоо	Статисикч	-*-	Энгэрийн хороо	86580080
40	Б.Пагма	Багш	-"-	Төв, 12 айл орон сууц	88086063
41	Б.Цэндсүрэн	Багш	Идэвхтэн	Энгэрийн хороолол	89991980
42	Г.Маамхүү	Сувилагч	-*-	Майхан ар	89448667
43	Х.Энхжаргал	ЭМТ ня-бо	-*-	Залаа хороолол	80225553
44	Г.Анхцэцэг	Асрагч	-"-	Майхны ар	89910865
45	Д.Баатарзориг	ЭМТ-ийн нярав	-"-	Залаа хороолол	91600419
46	Ц.Пүрэвдорж ӨВА 24-29	ЭМТ-ийн жолооч	Жолооч	Майхны ар	89997976
47	**Хэсгийн төлөөлөгч**	**Хэсгийн төлөөлөгч**	**Хэв журам сахиулах бүлгийн дарга**	**Орон сууц**	*
48	Б.Батбаяр	ИТХТ-ийн н/б дарга	Идэвхтэн	Энгэрийн хороолол	91011339 89164976
49	Ц.Энхболд	Майхан БЗД	Идэвхтэн	Майханы ар	89248423
50	Ц.Мөнхдэлгэр	Цагдаа	-"-	Орон сууц	80636413
51	Д.Батбаяр	Цариг БЗД	-*-	Төвийн хороолол	88600128
52	Г.Оюун	ЗДТГ-ын үйлчлэгч	Мэдээ хүргэгч	Төвийн хороолол	88721227 89451227
53	Я.Дагмидмаа	ЗДТГазар Нягтлан бодогч	-*-	Олон байшин	99501083 86704969
54	Ц.Чанцалдулам	Шуудан	-"-	Төвийн хороолол	99830877
55	**Б.Анхбаяр**	**Улсын нөөц**	**Сайн дурын ханы бүлгийн дарга**	**Орон сууц**	**96758485**
56	О.Алтангэрэл	Цахиурт БЗД	Ухуулагч	Энгэрийн хороолол	88168832
57	Б.Энхтуул	НДБайцаагч	Идэвхтэн	Залаа хороолол	80001595
58	Т. Байгалмаа	Сургуулийн эмч	-"-	Энгэрийн хороолол	95721229
59	Д.Энхтуяа	ТСМэргэжилтэ н	-*-	Залаа хороолол	88331163
60	Ц.Оюун-Эрдэнэ	ЗДТГазар Улсын бүртгэгч	-*-	Залаа хороолол	88260027
61	С.Жаргалсайхан	Улаан-Овоо БЗД	-"-	Төвийн хороолол	88405059
62	Д.Чанцал	4-р БЗДарга	-"-	Энгэрийн хороолол	99328985
63	Ц.Даваанyam	Гялс төгрөг	-"-	Залаа хороолол	80261021
64	Д.Бат-Эрдэнэ	Цаг уурын ажиглагч	Холбоочин	Төвийн хороолол	95804902
65	н.Үүрцайх	СТөв	-*-	Залаа хороолол	88263278
66	Э.Эрдэнэчимэг	НБодлогын мэргэжилтэн	-*-	Залаа хороолол	88549985

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр Дугаар А/37 Сант сум

Урамшуулал олгох тухай

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.1, 3.12 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч Б.Соёлмаад 1 дүгээр улирлын мөнгөн урамшууллыг үндсэн цалингийн 60 хувиар тооцож олгосугай.

2. Дээрх мөнгөн урамшууллыг 3 дугаар сарын цалингаас тооцож олгохыг сумын Эрүүл мэндийн нягтлан бодогч (Х.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

13800007

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр Дугаар А/38 Сант сум

Урамшуулал олгох тухай

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.1, 4.5, 4.7 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Ганчимэг, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч Х.Мөнхцэцэг нарт улирлын мөнгөн урамшууллыг 45 хувиар тус тус тооцож олгосугай.

2. Урамшууллыг тогтоосон хувь хэмжээгээр цалингийн санд багтаан олгохыг байгууллага хариуцсан нягтлан бодогч (Л.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

10800007

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр　　　　Дугаар А/39　　　　Сант сум

Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны “Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгжилтийг худалдан борлуулахыг хориглох тухай” А/136 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 21 нас хүрээгүй хүнд утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосугай.

2. Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийн худалдаанд хяналт тавих, өсвөр үе, хүүхэд залуучуудад электрон тамхины хор уршгийг таниулах, тамхинд донтохоос урьдчилан сэргийлэх, зөв дадалд уриалах арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, арга хэмжээний үр дүнг сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн (Г.Буянтогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА　　　　Б.АДЪЯАТОГТОХ

13800007

D:My.Doc.Zahiramj.zasag darga

Сант сумын Засаг даргын 2022 оны..03....
дугаар сарын ..25..ны өдрийн..А/39...дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г.Батзаяа (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Гишүүд: Т.Базарсад (Сургуулийн нийгмийн ажилтан)

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Т.Санлигмаа (Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан)

Г.Буянтогтох (Хууль, Эрх зүйн мэргэжилтэн)

Ц.Мөнхдэлгэр (Хэсгийн цагдаа)

-оОо-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/40 Сант сум

Хүүхэд үрчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл, 66.1, 66.3, Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд үрчлэн авахаар гаргасан хүсэлтийн дагуу тус сумын 4 дүгээр багийн иргэн Даваанямын Билгүүнтөгөлдөр (ЙЛ17211116)-ийг Сант сумын 4 дүгээр багийн иргэн Сумъяагийн Цэдэн (ЙК78062516), Дашийн Цэцэгдолгор (ЙЛ76020302) нарт үрчлүүлсүгэй.

2. Уг иргэний үрчлэлтийг бүртгэж, улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулахыг Улсын бүртгэгч (Ц.Оюун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

10000007

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр Дугаар А/41 Сант сум

Өмч хамгаалах зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмч хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч
Гишүүд: Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (Зөвшилцсөнөөр)
Хэсгийн төлөөлөгч
Санхүү албаны дарга
2 дугаар багийн Засаг дарга

2. Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх бодлого, хууль тогтоомж, хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, жил бүр төсвийн байгууллагуудын эд хөрөнгийн тооллогод хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллан, тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж байхыг Зөвлөлийн даргад даалгасугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

1000000001

D:My.Doc.Zahiramj.zasag darga

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/42 Сант сум

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2022 оны "Ээлжит цэрэг татлага явуулах тухай" А/173 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг хуваарийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсугай.

2. 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, комиссын ажил үүргийн хуваарийг хоёрдугаар, цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

3. Цэрэг татлагын товчооны дарга (Г.Бат-Эрдэнэ)-д ДААЛГАХ нь:

а. Цэрэг татлагын ажлыг аймгийн цэргийн штабаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус суманд зохион байгуулан ажиллах.

б. Цэрэг татлагын комиссын бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж, цэрэг татлагын үед сахилга хариуцлага, дэг журам, техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

в. Цэрэг татлагаар их, дээд сургуулиудын дөрөвдүгээр дамжаа буюу төгсөх дамжааны оюутнуудыг дуудахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

г. Цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг сахиж аймаг, сумын онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөн ажиллах.

4. Цэрэг татлагын үйл ажиллагаанд зарцуулагдах 840000 (найман зуун дөчин мянга)төгрөгийг сумын Засаг даргын нөөц сангийн зардлаас гаргаж, зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

D:My.Doc.Zahiramj.zasag darga

Сант сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/42 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Г.Бат-Эрдэнэ (Тамгын газрын дарга)

Гишүүд: Б.Соёлмаа (Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)

Б.Отгонбат (Соёлын төвийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ч.Ганчимэг (Сургуулийн захирал)

Т.Цэндмаа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Ц.Оюун-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

Ц.Мөнхдэлгэр (Хэсгийн цагдаа)

Д.Лувсанбалдан (Насан туршийн боловсролын нэгжийн багш)

Д.Батбаяр (Цариг багийн Засаг дарга)

О.Алтангэрэл (Цахиурт багийн Засаг дарга)

С.Жаргалсайхан (Улаан-Овоо багийн Засаг дарга)

Д.Чанцал (Залаа багийн Засаг дарга)

Ц.Энхболд (Майхан багийн Засаг дарга)

Сант сумын Засаг даргын 2022 оны 04
дугаар сарын 13-ны өдрийн А/42 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

САНТ СУМЫН ЦЭРЭГ ТАТЛАГЫН КОМИССЫН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

д/д	Комиссын гишүүдийн нэр /албан тушаал/	д/д	Хариуцах ажил үүрэг	Хугацаа
1	Г.Бат-Эрдэнэ	1	Цэрэг татлага зохион байгуулах комиссыг Засаг даргын захирамжаар томилох	04/13
		2	Цэрэг татлагын комиссыг хуралдуулах	04/13
		3	Цэрэг татлагын комиссын гишүүн бүрийг үүрэгжүүлэх	04/13
		4	Бэлтгэл ажилд хяналт тавьж тодорхой удирдлагаар хангаж ажиллах	04/13-24
		5	Цэрэг татлагын комиссын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх	04/14
		6	Цэрэг татлагын байр засуулах	04/23
		7	Аймгийн цэрэг татлагын товчоог ирэхэд сумын Цэрэг татлагын комиссын гишүүдийг бүрэн байлгах	04/22
		8	Цэрэгт татагдах эрчүүдийн нэрсийн жагсаалтыг 2 хувь бичиж гаргах	04/22
		9	Цэргийн зарлан дуудах хуудсыг хүн бүт бичиж багийн Засаг дарга нарт өгөх	04/09
		10	Сумын ЭМТөвтэй хамтран сумын цэргийн насны залуучуудын эрүүлжүүлэх	04/15-17
		11	Сумын ЭМТөвтэй хамтран сумын цэргийн насны залуучуудын эрүүлжүүлсэн тайланг гаргах	04/22
		12	Сумын "Насан туршийн боловсрол"-ын мэргэжилтэнтэй хамтран бичиг үсэг үл мэдэгч иргэдийн судалгааг гаргаж зохион байгуулсан ажлын тайланг гаргах	04/22
		13	Ирсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх /БЗДарга/	04-22
		14	Сумын Засаг даргын захирамжаар архи, согтууруулах ундаа зарахыг түр хугацаагаар хаах	04/23
		15	Аймгийн цэрэг татлагын товчоог хүлээн авч байрлуулах	04/ 23
		16	Цэрэг татлагын товчооны дүнгийн хуралд комиссын гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр хамруулах	04/23
		17	Цэргийн комиссоор орж байгаа залуучуудын бүртгэлийг "EXSELL" программ бичилт хийх	4/18
		1	Цэрэгт татагдах эрчүүдийн нэрсийн жагсаалтыг 100 настны статистик судалгаатай харицуулан 2 хувь "EXSEL" программ бичиж бэлэн болгох /Т.Цэндмаа/	04/19

2	Багийн Засаг дарга нар	2	Зарлан дуудах хуудсыг багийн цэрэг татагдагч иргэн бүрт өгч хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулан баталгаажуулж тооцоо	04/13-22
		3	Цэрэг татлагад шаардагдах хоол, хүнсний материалыг хувиарын дагуу авч ирэх / хавсралтаар /	04/22
		4	Ар гэрийн гачигдлын учир чөлөөлүүлэхийг хүссэн иргэдийг сумын цэрэг татлагын товчоогоор нэг бүрчлэн хэлэлцүүлж зохих журмын дагуу шийдвэрлүүлсэн байх	04/22
		5	Цэрэг татагчдын анкетийг шинэчлэгдсэн загвараар 2 хувь үнэн зөв комьютероор бичүүлж, зураг наасан, ам бүлийн талаар шинэчлэн тодотгож дэлгэрэнгүй бичсэн байх	04/18-20
		6	МУЗГ-ын 2016 оны 215 дугаар тогтоолын дагуу цэргийн албыг дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 1996 оны нийт иргэдэд мэдэгдэл хүргэж бэлэн байлгах	04/22
		7	Оюутан сурагчдад суралцаж байгаа сургуулийн тодорхойлолтыг албан бичгээр баталгаажуулан авчирахыг албан ёсоор мэдэгдэх	04/13-20
		8	Зарлан дуудах хуудас авч цэрэг татлагад ирээгүй тасалсан иргэдэд зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээ авах	04/24
		9	Цэрэг татлагаар орох хүүхдийг ЗДТГазарт 08 цагт бэлэн байлгах	04/24
3	Б.Соёлмаа ЭМТ-ийн эрхлэгч эмч	1	Сумын хэмжээнд тайван цагт цэргийн албанд үл тэнцэх иргэдийг аймгийн эмчийн үзлэгээр оруулах	04/18
		2	Сумын цэрэг татлагын үйл ажиллагаанд дайчлагдан ажиллах эмч, сувилагч нарыг үүрэгжүүлж, бэлтгэл ажлыг хангах	04/24
		3	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байранд тавих тоног төхөөрөмжийг бэлтгэж тавих	04/23
		4	Цэргийн насны залуучуудын эрүүлжүүлсэн тайланг гаргаж өмнөх оныхтой харицуулсан судалгаа, өвчлөл тус бүр дээр өссөн, буурсан үзүүлэлтээр нарийвчлан гаргах	04/22
		5	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байрны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах	04/24
4	Г.Буянтогтох ХЭЗМэргэжил-тэн	1	Цэргийн албаны тухай хууль болон бусад холбогдох журмыг гаргаж сурталчилах	04/24
		2.	Цэргийн үүрэгтний үнэмлэх бичиж, тооцоо хийх. Гэрээт цэргийн албаны ач холбогдол, гүйцэтгэх үүргийг сурталчилах.	04/24
		1	Цэрэг татагдагч иргэн бүрт багийн Засаг дарга нартай хамтран анкет 2 хувь бичих	04/13-19

5	Т.Цэндмаа Архив, бичиг хэргийн эрхлэгч	2	Цэрэг татлагын өдөр бүртгэл, шивэлт хийх	04/20
		4	Цэрэг татлагын товчооны дүнгийн хуралд комиссын гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр хамруулах	04/24
6.	Улсын бүртгэгч Ц.Оюун-Эрдэнэ	1.	Насанд хүрсэн залуучуудыг бүрэн иргэний үнэмлэхжүүлсэн байх	04/22
		2.	Цэрэг татлагын өдөр бүртгэл, шивэлт хийх	04/22
5	Б.Оггонбат	1.	Узель болон цэргийн тухай дууны бичлэг бэлтгэж байршуулах	04/23-24
		4	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг дулаан, гэрэлтүүлэг сайтай байлгаж, хивс дрож дэвсэн, агааржуулалттай шаардлага хангасан, комисс ажлаа явуулах нөхцийг бүрдүүлсэн байх	04/23
6	Ч.Ганчимэг	1	Аймаг, сумын цэрэг татлагын товчооны байрыг засаж тохижуулах	04/22
		2	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байр засах /том ширээ-2, 10 жижиг ширээ, 26 ш сандал, 2 том хивс, жижиг урт хивс/	04/22
		3	Комиссын гишүүдийн хоолны цэс гаргаж, цагт нь хооллуулах	04/24
			Тамхи татах цэгийг тогтоож тэмдэглэгээ хийсэн байх	04/22
7	Я.Дагмидмаа Г.Оюун	1	Цэрэг татлагаас гарах зардал Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах, хүнс барааны бэлтгэл ажлыг хангах	04/23
		2	Цэрэг татлагын товчооны хоолны чанар, хооллох цагт хяналт тавих	04/22
8	Ч.Баярсайхан Ч.Баярбат	1	Цэрэг татлагаар орох хүүхдийг ЗДТГазарт 08 цагт бүртгэж бичиг баримтыг шалгаж оруулах	04/24
		2	Цэрэг татлагаар орж байгаа залуучуудыг эмх цэгц, аюулгүй байдалд хяналт тавих	04/24
9	Ц.Мөнхдэлгэр	1	Засаг даргын захирамжийг дэлгүүрүүдэд тараах хяналт тавьж ажиллах	04/23-24
		2	Цэрэг татлагын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллах	04/24
		3	Цэргийн албанд татагдаж байгаа иргэдийн дулаан хувцас, тээврийн хэрэгслийн аюулгүй байдалд онцгой анхаарч ажиллах	04/24

-oOo-

Сант сумын Засаг даргын 2022 оны ..04..
дугаар сарын 12...ны өдрийн..А/42..дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

2022 ОНЫ ЦЭРЭГ ТАТЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

№	Шаардагдах зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Нэг. Ариутгалын бодис, хэрэгсэл				
1.1	Жавелин	300 мл/гр- 1ш	20,000	20,000
1.2	Маск	50 ш	300	15,000
1.3	Санитол	500 гр- 10 ш	10,000	100,000
1.4	Зай барих шалны наалт	15 ш	1,500	22,500
1.5	1 удаагийн бээлий	1 хайрцаг	30,000	30,000
1.6	Малгай	1 хайрцаг 50ш	600	30,000
1.7	Улавч	1 хайрцаг	-*-	СОК-ын нөөц
Хоёр. Бичиг хэрэг				
2.1	Бичгийн цаас	3 ш	13,000	39,000
2.2	Бал	8 ш	500	4,000
2.3	Хавтас /нүхтэй/	100 ш	200	20,000
2.4	Хавтас /кор/	1ш	5,000	5,000
2.5	Фото цаас /наалддаг/	1 ш	10,000	10,000
Гурав. Хоол, хүнсний зардал				
3.1	Цэвэр ус	24 ш	800	19,200
3.2	Жүүс	20 ш	2,500	50,000
3.3	Тавгийн чихэр	2 кг	12,000	24,000
3.4	Жимс	4 кг	8,000	32,000
3.5	Хонь	1 ш	250,000	250,000
3.6	Гурил	15 кг	1,500	22,500
3.7	Будаа	10 кг	3,000	30,000
3.8	Хүнсний ногоо	10 кг	2730	27,300
3.9	Сальфетик /хуурай/	4 боодол- 100 ш	3,000	12,000
3.10	Сальфетик /нойтон/	5 ш	3,500	17,500
3.11	Нэг удаагийн аяга	200 ш	100	20,000
3.12	Кофе	50 ш	500	25,000
3.13	Боллонтой цэвэр ус	3 ш	5,000	15,000
	Бүгд			**840,000**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/43 Сант сум

Хөрөнгө гаргах тухай

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, аймаг, сумын аварга малчид болон сумын оны тэргүүнүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар гаргаж шагналд 3,248,500 (гурван сая хоёр зуун дөчин найман мянга таван зуу) төгрөг, байгууллагын болон 80-аас дээш настай ахмадын нэрсийг хоёрдугаар хавсралтаар гаргаж бэлгэнд 1,926,050 (нэг сая есөн зуун хорин зургаан мянга тавь) төгрөг, шагнал урамшууллын зардлыг гуравдугаар хавсралтаар гаргаж нийт 5,174,550 (таван сая нэг зуун далан дөрвөн мянга таван зуун тавь) төгрөгийг зарцуулсугай.

2. Эмзэг бүлгийн хүүхдийн шүдний эмчилгээнд 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх зарцуулагдах нийт 6,174,550 (зургаан сая нэг зуун далан дөрвөн мянга таван зуун тавь) төгрөгийг сумын Засаг даргын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Я.Дагмидмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

D:My.Doc.Zahiramj.zasag darga

Сант сумын Засаг даргын 2022 оны...04...
дугаар сарын...13...ны өдрийн...A/49...дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

СУМЫН 2021 ОНЫ ТЭРГҮҮНҮҮД

Сумын аварга малчид:

1. А.Энхбат- 1-р баг
2. Ж.Шаарав- 1-р баг
3. Д.Чинбат- 1-р баг
4. Ө.Ганболд- 2-р баг
5. Ч.Улаанхүү- 2-р баг
6. С.Больхүү- 2-р баг
7. Н.Цогхийморь- 3-р баг
8. М.Лхагвасүрэн- 3-р баг
9. Ө.Шижирбаатар- 3-р баг
10. Ц.Анхбаяр- 4-р баг
11. С.Цэдэн- 4-р баг
12. С.Цэдэндорж- 4-р баг
13. Т.Үүрцайх- 5-р баг

2021оны тэргүүнүүд:

1. Тэргүүний төрийн түшээ- Г.Батзяа
2. Тэргүүний багш- О.Мөнхжарга
3. Тэргүүний санхүүгийн ажилтан- Д.Баатарзориг
4. Тэргүүний эрүүл мэндийн ажилтан- Т.Санлигмаа
5. Тэргүүний тээвэрчин- Ц.Баяр
6. Тэргүүний сурагч- Д.Баярдорж
7. Тэргүүний үйлчилгээний ажилтан- О.Бямбасүрэн
8. Соёлын Тэргүүний ажилтан- Ж.Түмэнжаргал

-oOo-

Сант сумын Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 13 ны өдрийн [illegible] дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

САНТ СУМЫН 2021 ОНЫ 80 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ АХМАДЫН НЭРС

№	Овог нэр	Регистерийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг
1	Нацаг Цэгмэд	Зл25031400	96	Өв сант 4-баг майхан
2	Цэгмэд Авдай	Йл25102018	96	Өв сант 4-баг Гүүн гашуун
3	Цэнджав Хорлоо	Йл27030701	94	Өв сант 2-баг Ногоон толгой
4	Чойндон Дагваа	Йл33082013	88	Өв сант 2-баг Гүн шанд
5	Цэдэн-Иш Надмид	Йл34051001	87	Өв сант 3-баг Бургалтай
6	Дэжид Цэрэнбат	Йл34110718	87	Өв сант 4-баг
7	Зундуй Намжилмаа	Ею35061002	86	Өв сант3-баг сумын төв
8	Жамбалдорж Сандагбанди	Йл35040213	86	Өв сант 3-баг сумын төв
9	Жадамба Очирдорж	Йл36051515	85	Өв сант 3-баг сумын төв
10	Ламжав Гүнгээ	Йл36043018	85	Өв сант 5-баг сумын төв
11	Аюур Жадамба	Йл36051817	85	Өв сант 5-баг Хөндий
12	Магсар Сүрэнжав	Йл36090522	85	Өв сант 2-баг Өвдгийн энгэр
13	Банди Цэрэндулам	Йл37060104	84	Өв сант 3-баг сумын төв
14	Дашдорж Дэндэвдорж	Йл37102519	84	Өв сант 4-баг сумын төв
15	Чойжав Сурмаа	Йл37081301	84	Өв сант 2-баг
16	Чимэддорж Эхнэр	Йл37071101	84	Өв сант 5-баг Майхан төв
17	Дуг Бямбажав	Йл37081001	84	Өв сант 5-баг Майхан төв
18	Баточир Тогооч	Йл38041200	83	Өв сант 1-баг
19	Даш Магсаржав	Йл38122200	83	Өв сант 2-баг
20	Дамдин Дашзэвгэ	Йз39042009	82	Өв сант 2-баг
21	Раднаа Жагд	Йл39011016	82	Өв сант 3-баг
22	Ренчин Хорлоо	Йл40102002	81	Өв сант 1-баг
23	Цэдэнбал Өлзийбат	Йл40051612	81	Өв сант 2-баг
24	Цэрэнсоном Цэдэниш	Йл40051517	81	Өв сант 2-баг
25	Бүрэнжаргал Ичинхорлоо	Йл40050200	81	Өв сант 3-баг сумын төв
26	Данзан Цэвэл	Йл40100103	81	Өв сант 3-баг сумын төв
27	Довдон Жигжидсүрэн	Йл40070513	81	Өв сант 3-баг шуудуу
28	Сэрээнэндавга Мягмар	Йл40031409	81	Өв сант 4-баг сумын төв
29	Амарцогт Сумъяа	Йл40091516	81	Өв сант 4-баг сумын төв
30	Бадамдоо Дуламсүрэн	Йл40042307	81	Өв сант 4-баг сумын төв
31	Равдандорж Давгадорж	Йл40112016	81	Өв сант 5-баг сумын төв
32	Сэрээтэр Цэвэлравжаа	Йл41012015	81	Өв сант 2-баг ногоон толгой
33	Цамба Шуурай	Йл41121101	81	Өв, Сант 1-р баг

34	Дамбий Сүхбаатар	Йл41101905	81	Өв Сант 2-р баг
35	Довчин Цэдэн	Йл41082512	81	Өв Сант 4-р баг
36	Тарзад Мангалжав	Йл42020501	81	Өв Сант 4-р баг сумын төв
37	Готов Сумъяа	Йл42021208	81	Өв Сант 3-р баг

-oOo-

Сант сумын Засаг даргын 2022 оны...04...
дугаар сарын 13...ны өдрийн...А/143...дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Фото цаас	1 ширхэг	12,500	12,500
2	Хадаг	4 ширхэг	5,000	20,000
3	А4 Жааз	3 ширхэг	8,000	24,000
4	А4 Жааз	4 ширхэг	9,500	38,000
5	Тууз	1 ширхэг	30,000	30,000
6	Үнэмлэхний хавтас	24 ширхэг	2,000	48,000
7	Медаль	4 ширхэг	10,000	40,000
8	Медаль	22 ширхэг	4,000	48,000
9	А5 өргөмжлөл	10 ширхэг	7,000	70,000
10	А5 Батламж	2 ширхэг	7,000	14,000
11	А4 Өргөмжлөл	10 ширхэг	13,000	130,000
12	Өргөмжлөл бичилт	1	99,000	99,000
13	Мөнгөн шагнал			1,050,000
14	Домбо	1 ширхэг	400,000	400,000
15	Халбага	5 ширхэг	185,000	925,000
16	Аяга	1 ширхэг	260,000	260,000
Нийт				**3,248,500**

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр — Дугаар А/44 — Сант сум

Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: О.Ганпүрэв (Засаг даргын орлогч)
Нярав: Г.Оюун (Засаг даргын Тамгын газрын нярав)
Жолооч: Д.Батбаатар (иргэдийн Төлөөлөгчдийн хурлын жолооч)
Гишүүд: Т.Ишдорж (Татварын байцаагч)
Д.Баатарзориг (Эрүүл мэндийн төвийн нярав)
Б.Пүрэвсүрэн (Цэцэрлэгийн нярав)
Ч.Баярмандах (Соёлын төвийн дуу хөгжмийн багш)
Ц.Пүрэвдорж (Эрүүл мэндийн төвийн жолооч)
Д.Батбаатар (Сургуулийн нярав)
Багийн засаг дарга нар

2. Гал унтраах сайн дурын хэсгийн гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дадлага чадвар олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг шинэчлэн байгуулах тухай” А/27 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/45 Сант сум

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай

Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Монгол Улсын “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль”- ийн 7 дугаар зүйлийн 7.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны “Тээврийн хэрэгслийн албан татвар хураах техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай” А/92 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн 2022 оны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, жолоочийн даатгалд даатгуулах, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах сумын комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

2. Сумын салбар комиссын дарга (О.Ганпүрэв)-т ДААЛГАХ нь:

а/. Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөрийн аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт бүрэн шилжүүлж, татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

б/. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

в/.Сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харъяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх ажлыг зохион байгуулах.

3.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хуулийн дагуу хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг комиссын дарга (О.Ганпүрэв)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

10600000

D:My.Doc.Zahiramj.zasag darga

Сант сумын Засаг даргын 2022 оны...04...
дугаар сарын 15.....ны өдрийн...А/45....дугаар
захирамжийн хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР ХУРААХ, ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ СУМЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: О.Ганпүрэв (Засаг даргын орлогч)

Гишүүд: Т.Ишдорж (Татварын байцаагч)

Г.Батзаяа (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Ц.Мөнхдэлгэр (Хэсгийн цагдаа)

Д.Батбаяр (Цариг багийн Засаг дарга)

О.Алтангэрэл (Цахиурт багийн Засаг дарга)

С.Жаргалсайхан (Улаан-Овоо багийн Засаг дарга)

Д.Чанцал (Залаа багийн Засаг дарга)

Ц.Энхболд (Майхан багийн Засаг дарга)

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/46 Сант сум

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалт, үзлэг, тандалт, халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4дэх заалт, 2022 оны аймгийн Засаг даргын “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/188 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалт, үзлэг, тандалт халдваргүйтгэлийн ажлыг 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний хооронд тус тус зохион байгуулахыг “Хөх тойром”, “ЭММА”, “Эрдэнэ хайрханы өгөөж”, “Булангийн харз” мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай.

2.Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулж, барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт үүрэг болгосугай.

4.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалт, үзлэг, тандалт халдваргүйтгэлийн ажлуудыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар батлахсугай.

5.Мал эмнэлгийн гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалт, үзлэг, тандалт, халдваргүйтгэлийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга, мал эмнэлгийн улсын байцаагч (Х.Гантуяа)-д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (О.Ганпүрэв)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ

D:My.Doc.Zahiramj.zasag darga